

Монгол, англи хэлний сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн танин мэдэхүйн зүйрлэл (“уйтгар гуниг” концептын жишээн дээр)**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ**

Мөнхбатын БУЛГАНЦЭЦЭГ*

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн Англи, герман хэлний тэнхим***Received:** May 17, 2024**Revised:** August 29, 2024**Accepted:** November 1, 2024

Хураангуй: Сэтгэл хөдлөл нь маш нарийн бүтэц, тогтолцоотой хийсвэр ертөнц юм. Хүн төрөлхтөн сэтгэл хөдлөлийг хэрхэн таньж мэдэж, ухаарч ойлгосныг хэл, соёл, сэтгэлгээний талаас судлахад танин мэдэхүйн зүйрлэл чухал үүрэгтэй. Зүйрлэл нь хэлний уран яруу хэрэглүүр хэмээх уламжлалт ойлголтоос илүү хол давсан, өргөн хүрээтэй, гүнзгий утгатай, хэлний нарийн үзэгдэл тул судлаачдын анхаарлыг татсаар байна. Монгол, англи хэлний уйтгар гунигийг илэрхийлсэн зүйрлэл нь босоо ба сав бүдүүвчийн хүрээнд үүсдэг хэлний бүтээлч зүйрлэл юм.

Иймд бид энэ судалгаанд сэтгэл хөдлөлийн үндсэн ай болох “уйтгар гуниг” концептыг сонгож, судлаачдын дэвшүүлсэн танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолд тулгуурлан уг концептын мөн чанарыг тодорхойлж, зүйрлэлийн сурвалж хүрээг тодорхойлон, хоёр хэлэнд илэрч буй нийтлэг хийгээд онцлог шинжийг илрүүлэхийг зорьсон. Бид энэ судалгаанд хэлний баримтыг айчлан, дэд айг тодорхойлж, тэдгээрт дүн шинжилгээ хийж, монгол хэлний уйтгар гунигийн тухай зүйрлэлийн бүтэц, туршилагын үндсийг тодорхойлсон болно. Хэлний жишээ баримтад анализ хийхэд энэ сэтгэл хөдлөл олон сурвалж хүрээтэй, нарийн бүтэцтэй болох нь тогтоогдсон. Энэ нь монгол, англи үндэстний ертөнцийг үзэх үзэл, арга ухаан, сэтгэлгээний онцлогтой холбоотой байна. Монгол, англи хэлний уйтгар гунигийг илэрхийлсэн зүйрлэлүүд биеийн үйл хөдлөл, туршилагын үндэс, соёлд суурилан үүссэн бөгөөд өөр хэл, соёлт үндэстнүүд сэтгэл хөдлөлийг өөр өөрийн арга ухаанаар таньж мэддэг болохыг энэ судалгаа харуулж байна.

Түлхүүр үг: хийсвэр ертөнц, туршилага, дүр бүдүүвч, сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл

* © М.Булганцэцэг, 2024
Email: bulgaflower@gmail.com

Conceptual Metaphor in Mongolian and English Languages (Using the Examples of the Concept of Sadness)

BULGANTSETSEG Munkhbat

Department of English and German Languages,
School of Social Sciences and Humanities, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Emotions represent a complex and abstract domain with a structured system. Cognitive metaphors are essential in understanding how humans perceive and interpret emotions through language, culture, and thought. Metaphors draw significant attention from researchers because they go beyond the traditional notion of literary devices; they are multifaceted, rich in meaning, and a subtle linguistic phenomenon. The metaphor of sadness in both Mongolian and English is a productive linguistic construct formed through container and vertical schemas.

This study focuses on the concept of sadness, a fundamental emotional category, to explore its essence within the framework of cognitive linguistics. Our goal is to identify the source domains of metaphors and highlight both the similarities and differences between the two languages. We analyzed linguistic evidence to define and categorize the sub-concepts of sadness in Mongolian and to examine the structural and experiential foundations of sadness metaphors. Our findings indicate that the concept of sadness involves multiple source domains and a complex structure, shaped by the worldviews, life experiences, and cognitive frameworks of both Mongol and English-speaking cultures. This research also shows that metaphors for sadness in Mongolian and English are rooted in bodily movements and experiential bases, revealing that different cultures and languages perceive emotions in distinct ways.

Keywords: abstract world, experience, image schema, thought, world view

1. Удиртгал

Танин мэдэхүй бол аливаа юм, үзэгдлийг гадаад, дотоод талаас нь ухаж ойлгон, мэдлэг хуримтлуулах хүний тархины үйл юм. Хүний амьдрал бүхэлдээ танин мэдэхүйд суурилдаг. Хүн дотоод ертөнцөө хэрхэн таньж мэдэж, ухаарч ойлгосныг судалгааны түвшинд тайлбарлах нь орчин үеийн хэл шинжлэлийн нэг гол хандлага болж байна.

Сэтгэл хөдлөл нь маш нарийн бүтэцтэй, өргөн хүрээтэй, олон далд утгыг илэрхийлдэг хийсвэр ойлголт юм. Судлаачид сэтгэл хөдлөлийг *аз жаргал, уйтгар гуниг, уур уцаар, айдас, хайр гэсэн* үндсэн таван айд хувааж үздэг. (Фехр, Рассел 1984), Фрижда, Маркан, Сато, Виерс, 1995). Сэтгэл хөдлөл нь салбар дундын судлагдахуун болон өргөжиж, энэ чиглэлээр олон бүтээлүүд гарч байгаа нь энэ талын судалгааг цаашид нарийвчлан судлахад гол чиг баримжаа болж байна.

Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн хэлний тогтвортой илэрхийллүүдийг танин мэдэхүйн хэл шинжлэлийг талаас судалж, дотоод ертөнцийн олон үзэгдлийн нууцыг тайлахад зүйрлэл чухал үүрэгтэй. Бид хийсвэр, бодит бус зүйлийг бодит зүйлийн хүрээнд ойлгогдгийг танин мэдэхүйн хэл шинжээчид тогтоосон байна. (Лакоф⁸ & Жонсон⁹, 1980; Ковексес¹⁰, 2002). Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн хэлний тогтвортой илэрхийллүүд нь хэлний нарийн үзэгдэл учраас бид тэдгээрийг хийсвэрлэн ойлгохын тулд бүтэц, тогтолцооных нь хүрээнд авч үзэх хэрэгтэй. (Ковексес, 1986, 1990, 2002, 2005, 2008; Лакоф, 1987; Барселона¹¹, 1986)

Хүн төрөлхтөн хийсвэр ертөнцийг таньж мэдэхийн тулд гадаад ертөнцийн юм, үзэгдэлтэй жишин адилтгаж, мэдлэг туршлага хуримтлуулсны үр дүнд хэлний илэрхийллүүдийг бүтээж, үгийн сангаа баяжуулсаар ирсэн. Монголчуудын соёл, нүүдлийн ахуй амьдралтай холбоотой сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн зүйрлэл, солин нэрлэхүй нь монгол хэлний бичгийн эх сурвалжид их илэрч байна. Бид энэ судалгаанд монгол, англи хэлний "уйтгар гуниг" концептын мөн чанарыг тодорхойлж, уг танин мэдэхүйн зүйрлэлийн сурвалж хүрээг тодорхойлон, хоёр хэлэнд илэрч буй соёлын нийтлэг хийгээд онцлог шинжийг илрүүлэхийг зорьсон болно.

2. Судалгааны арга зүй

Энэ судалгааны судлагдахуун нь "уйтгар гуниг" сэтгэл хөдлөлийн цогц ойлголт юм. "Сэтгэл хөдлөл" цогц ойлголтыг ой ухаандаа төсөөлөн буулгавал туршлагын ямар үндэст суурилсан үүссэн бэ? Хэлний зүйрлэл нь байгаль дэлхий, амьтан ургамлын төрөл зүйл, байгалийн юм үзэгдэл, аливаа ард түмний итгэл үнэмшил, сүсэг бишрэл, мал аж ахуй, газар тариалан эрхэлж ирсэн туршлагад суурилсан уу, эсвэл энэ бүхний цогц нэгдэл болох материаллаг болон оюуны соёлын илэрхийлэл үү гэдэг асуулт урган гарч байна. Уг судалгаанд "уйтгар гуниг" концептын мөн чанарыг судалж, хэлний баримтыг айчлан, дэд айг тодорхойлж, тэдгээрийг тайлбарлан дүн шинжилгээ хийж, уг зүйрлэлийн бүтэц, туршлагын үндэс, соёлын загварыг тодорхойлсон болно.

3. Англи хэлний "уйтгар гуниг"-ийн тухай зүйрлэл

"Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн цогц ойлголтуудыг бүрэн гүйцэд судлаагүйгээс сэтгэл хөдлөлийг зөвхөн мэдрэмж гэж үздэг" (Лакоф, 1987: 380). Ж. Лакоф 1987 онд "уур хилэн" сэтгэл хөдлөлийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн талаас судалж, энэхүү цогц ойлголт нь уялдаа холбоо бүхий бүтэц, тогтолцоотой болохыг тодорхойлсон.

⁸ Lakoff, G

⁹ Johnson, M

¹⁰ Kövecses, Z

¹¹ Barcelona, A

Сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд хэлний хэрэглүүр дотроос танин мэдэхүйн зүйрлэл чухал үүрэгтэй. Дотоод ертөнцийн олон өнгө аясыг илэрхийлдэг зүйрлэсэн үг хэллэгүүд нь хүний дотроос өөрөө гарч ирдэг зүйл биш, харин тархинд бүрэлдэн бий болсон танин мэдэхүйн зүйрлэл, солин нэрлэхүйн тогтолцооны илэрхийлэл гэдгийг эрдэмтэд судлан тогтоосоор байна.

Ж. Лакоф “Танин мэдэхүйн зүйрлэл нь нэг зүйлийг нөгөө зүйлийн хүрээнд шилжүүлэн ойлгож, илэрхийлэх оюуны үйл мөн.” (1980: 5) гэсэн байна. Тэрээр бүтээлдээ танин мэдэхүйн зүйрлэлийн талаар дараах чухал санааг дэвшүүлсэн. Үүнд:

- Зүйрлэл бол хийсвэр санаа, хийсвэр ухагдахууныг ойлгох гол хэрэгсэл юм.
- Зүйрлэлийг зөвхөн хэлний хэрэглүүр гэж үзэх нь өрөөсгөл ойлголт болно.
- Зүйрлэл бол танин мэдэхүйн үйл явцын салшгүй нэг хэсэг юм.
- Хэл бүхэнд байдаг зүйрлэсэн үг хэллэгүүд нь танин мэдэхүйн зүйрлэлийг илэрхийлж буй хэлбэр юм.
- Бидний сэтгэхүйд бүрэлдсэн тогтсон цогц ойлголтын тогтолцоонд аливаа юм, үзэгдлийг зүйрлэсэн шинж бий. Гэвч энэ тогтолцооны ихэнх хэсэгт ийм шинж байхгүй. Учир нь бид зүйрлэж буй юм, үзэгдлийг зүйрлэгдэж буй ухагдахууны хүрээнд ойлгодог.
- Бид хийсвэр зүйлийг бодит зүйлийн шинж чанартай адилтган зүйрлэж илэрхийлдэг.
- Зүйрлэл нь сурвалж хүрээгээр илэрдэг хийсвэр ертөнцийн дүр зураг юм.
- Зүйрлэлийг бүтээж буй хоёр ухагдахуун нь бүх шинжээрээ хоорондоо бүрэн тохирохгүй ч зарим шинжээрээ тохирох бөгөөд бүтцийн хувьд системт шинжтэй.
- Хийсвэр ертөнцийн дүр зураг нь сурвалж хүрээний ойлголт, зорилтот хүрээний ойлголт гэсэн хоёр өөр хүрээний хоорондох оршихуйн холбоо юм.
- Хийсвэр ертөнцийн дүр зураг нь үгийн хэлбэр, утгын холбоог илэрхийлэхгүй бөгөөд хүний бие махбод, өдөр тутмын үйл болоод туршлагад суурилдаг.
- Хийсвэр ертөнцийн дүр зургийг ухагдахууны, дүрийн гэсэн хоёр төрөлд хуваадаг.
- Зүйрлэл нь хүн төрөлхтний хуримтлуулсан туршлагыг ойлгож ухаарахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Зүйрлэл нь ухагдахууны ижил төстэй шинжид суурилагаас илүү туршлагын үндэсд тулгуурладаг.

Хийсвэр ертөнцийн дүр зураг нь түгээмэл болон түгээмэл бус шинжтэй. Энэ нь өөр өөр хэл, соёлд харилцан адилгүй бөгөөд хэл бүхэнд соёлын онцлог шинжийг хадгалсан өвөрмөц зүйрлэлүүд бий. Танин мэдэхүйн зүйрлэлийг дүр бүдүүвчээр

тодорхойлдог бөгөөд энэ бүдүүвч нь *босоо бүдүүвч*, *сав бүдүүвч* гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Дүр бүдүүвч нь сэтгэл хөдлөлийг дээш, доош чиглэсэн бүх зүйлээр хэмжиж илэрхийлдэг бол сав бүдүүвч нь хүн төрөлхтөн өөрийн биеийг гадар, дотортой сав гэж танин мэдсэн туршлагад суурилдаг. Дүр бүдүүвч нь хүний танин мэдэхүй, хийсвэр ертөнцийн дүр зургийг тодорхойлоход чухал үүрэгтэй.

“Дүр бүдүүвч гэдэг нь хүний бие орон зай, цаг хугацаа, бодит ертөнцийн юмс, үзэгдэлтэй харилцан үйлчлэлд орсноор туршлага хуримтлуулдаг бөгөөд тэдгээр туршлага бүр дотроо уялдаа холбоо бүхий нарийн бүтэцтэй болохыг тодорхойлдог танин мэдэхүйн хөдөлгөөнт загвар юм” (Жонсон, 1987: 14)

Уйтгар гуниг нь сэтгэл хөдлөлийн үндсэн айд багтдаг. Уйтгар гуниг бол хагацал зовлон, ямар нэг холбоо хэлхээ тасрах гэх мэт амьдралд тохиолдож буй зүйлд үзүүлж буй сэтгэлийн хариу үйлдэл юм. Бид хэн нэгнийг санах, хайртай нэгнээ алдах, зорьсон зүйлдээ хүрч чадахгүй үед уйтгарлаж гунигладаг.

Сэтгэл хөдлөл нь *эрч хүч*, *хяналт*, *эерэг сөрөг үнэлэмж*, *хүндрэл бэрхшээл*, *хор нөлөө* гэсэн олон талтай. Сэтгэл хөдлөлийн эрч өөр өөр түвшинд байдаг. Дараах зүйрлэлүүд нь сэтгэл хөдлөлийн эрч ямар түвшинд байгааг тодорхойлдог. (Ковексес, 2000: 41) Жишээ нь:

1. Intensity of emotion is amount/quantity (of substance in a container)
Сэтгэл хөдлөлийн эрч бол саванд байгаа бодисын хэмжээ
 2. Intensity of emotion is heat
Сэтгэл хөдлөлийн эрч бол дулаан
 3. Increase in intensity of emotion is growth
Сэтгэл хөдлөлийн эрч нэмэгдэж байгаа нь өсөлт
 4. Intensity of emotion is increase in effect (of force)
Сэтгэл хөдлөл эрчтэй бол хүч нэмэгдэнэ.
- A. Барселона, (1986) З. Ковексес (2000: 25-26) нар англи хэлний “уйтгар гуниг”-ийн тухай зүйрлэлийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн талаас судалж, сурвалж хүрээг дараах байдлаар тодорхойлсон байна.
5. Sad is down/ уйтгартай бол доошоо
He brought me down with his remarks. Түүний хэлсэн зүйл намайг *гонсойлгов*.
 6. Sad is dark/ уйтгартай бол харанхуй
He is in a dark mood. Тэр *баргар* байна.
 7. Sadness is a lack of heat/ уйтгартай байвал илч, дулаан дутагдана.
 - Losing his father put his fire out; he's been depressed for two years/
Эцгийгээ алдсанаас хойш түүний *нүдний гал бөхсөн*. Түүний сэтгэл хоёр жил хямарч байна.
 - Sadness is a lack of vitality/Уйтгартай бол эрч хүч дутагдана.
 - This was disheartening news/Тэр *урам хугалмаар* мэдээ байсан.

- Sadness is a fluid in a container/Уйтгар гуниг бол саванд байгаа шингэн
- I am *filled* with sorrow/Би уйтгар гунигт *автаад байна*.
- Sadness is a physical force/Уйтгар гуниг бол физикийн хүч
- That was *a terrible blow*/Тэр хүчтэй цохилт болсон.
- Sadness is a natural force/Уйтгар гуниг бол байгалийн хүч
- *Waves of depression came over him*/Уйтгар гуниг түүнийг бүхэлд нь эзэмдэв.
- Sadness is an illness/Уйтгар гуниг бол өвчин
- She was *heart-sick*/Time *heals* all sorrows/Түүний *сэтгэл өвдсөн*/Цаг хугацаа л түүний сэтгэлийг шархыг эдгээнэ дээ.
- Sadness is insanity/Уйтгар гуниг бол галзуурал
- He was *insane with grief*/Тэр уй гашууд автаж *галзуурав*.
- Sadness is a burden/Уйтгар гуниг бол ачаа.
- He *staggered under the rain*/Өвдөлт ихтэй байсан тул тэр хөл дээрээ *арай ядан тогтож байв*.
- Sadness is a living organism/Уйтгар гуниг бол амьд организм
- He *drowned his sorrow in drink*/Тэр уйтгар гунигийн ангалд *живэв*.
- Sadness is a captive animal/Уйтгар гуниг бол хашигдсан амьтан
- His feeling of misery *got out of hand*/Тэр шаналсан *сэтгэлээ барьж дийлэхгүй* байв.
- Sadness is an opponent/Уйтгар гуниг бол өрсөлдөгч тал
- He was *seized by a fit of depression*/Тэр *сэтгэлийн хямрал нөмрөн авав*.
- Sadness is a social superior/Уйтгар гуниг бол нийгэмд эзлэх байр суурь
- He was *ruled by sorrow*/Тэр уй *гашуугаас гарч чадахгүй* байна.

Англи хэлний “уйтгар гуниг” цогц ойлголт нь хүч-хөдөлгөөн гэсэн олон сурвалж хүрээтэй бөгөөд дээрх зүйрлэлүүд нь уйтгар гунигийг мэдэрч буй өнгө аяс, сэтгэлийн төлөв байдлыг илэрхийлж байна.

4. Монгол хэлний “уйтгар гуниг”-ийн тухай зүйрлэл

Тодорхой нэг сэтгэл хөдлөлийг судалж, танин мэдэхүйн хэв шинжийн загварыг тодорхойлоход ардын онол (folk theory) нь чухал үүрэгтэй. З. Ковексес (2000) сэтгэл хөдлөлийн онолыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Сэтгэл хөдлөл үүсэх шалтгаан → сэтгэл хөдлөл (сэтгэл хөдлөлийг хянах)
→ хариу үйлдэл

Дээрх бүдүүвч сэтгэл хөдлөл нь тодорхой шалтгааны улмаас үүсэх бөгөөд бид түүнд хариу үйлдэл үзүүлдгийг илэрхийлж байна. Нийгэм, соёлын орчинд ямар хариу үйлдлийг хүлээн зөвшөөрөх үү гэдэгт зааг хязгаар бий бөгөөд нийгэм нь сэтгэл хөдлөлийг хянах хэм хэмжээг тогтоодог. “Шалтгаан бол хүч

юм" зүйрлэл нь ерөнхий түвшний зүйрлэл бөгөөд ардын онол нь энэ зүйрлэлээс үүссэн байна. Энэ загварын гол санаа нь сэтгэл хөдлөлийг үүсгэж буй юм бүхнийг шалтгаан гэж хийсвэрлэн ойлгож, шалтгааныг сэтгэлийн төлөв байдлыг өөрчлөхөд нөлөөлөх хүч гэж үздэг. Үүссэн сэтгэл хөдлөл нь өөрөө шалтгаан болоод зогсохгүй сэтгэл зүйн, зан үйлийн, илэрхийллийн гэх мэт хариу үйлдэлд нөлөөлөх хүч юм гэж судлаачид үздэг. Ерөнхий түвшний ийм зүйрлэл үүсэж, хэрэглэгдэж ирснээс үзэхэд сэтгэл хөдлөл үүсэх туршлагын үндсийг динамик-хүчтэй холбон тайлбарлах боломжтой.

Хүн уйтгарлах үед толгой гудайж, царай цонхийж, эрч хүч, биеийн дулаан буурна. Мөн зүрхний цохилт удааширч, цусны даралт ихэсдэг. Сэтгэл зүйн хувьд таагүй, урам хугарсан, итгэл найдваргүй болсон мэт мэдрэмж төрдөг. Уйтгартай хүн аливаа зүйлээс хойш суух, бусдаас зайгаа барих, дуугаа хураах, идэвхгүй үлбэгэр болох, дотогшоо чиглэсэн хандлагатай болдог. (Давиз¹², 1969).

Бид аливаа зүйлийг сэрж мэдрээд зогсохгүй, юу мэдэрч байгаагаа ойлгож ухаарсны үндсэн дээр хариу үйлдэл үзүүлдэг. (Ж. Лакоф, 1987: 377). Уйтгар гуниг нь биеийн хөдөлгөөн, дууны өнгө, нүд, нүүр царайгаар илэрдэг бөгөөд түүнд хариу үйлдэл үзүүлж буй хүний зан үйл, сэтгэл зүй, төлөв байдлыг илэрхийлдэг хэлний хэрэглүүр бол *солин нэрлэхүй* юм. Танин мэдэхүйн зүйрлэлээс ялгаатай нь солин нэрлэхүй нь нэг хүрээ буюу нэг ухагдахууныг хамрах бөгөөд хүрээн дотроо төлөөлөх (stand-for relation) холбоо харьцаанд суурилна.

- “Аав минь ижийн тухай сонсож дээ” гэж бодсон Бат гүн санаа алдаад *харцаа бууруулан доош харлаа*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 98)
- Хэрэггүй. Ээж чинь намайг гомдоосон... Харин аав нь хүрээ орж суурьшаад эргэж ирж хүүгээ авна... гэхэд *Эрдэнийн хоолой нь зангирав*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 206)
- Би яасан азгүй хүн бэ? гэж *гунигтаа хахаж тасарсан битүү дуугаар хэлэв*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 99)
- ... “*нүүрэнд нь хур гуниг шингэсэн* ямар хачин хүүхэн бэ? Аль эсвэл над шиг түмэн зовлон туулсан амьтан юм болов уу? гэж бодож байлаа. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 137)
- Петр Батыг ажиглан харснаа *нүдэнд нь гүн бодол, зурвасхан гунигийн аль нэгэн нь тодрон*, шинелийнхээ халааснаас хатсан жижигхэн талх гаргаж өгөв. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х.15)
- Эрдэнийн *царай ямар ч өнгөгүй* болоод ганц үг дуугарсангүй. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 100)

Монголчууд шимт ертөнц болох ан амьтан, ургамал зэрэг амьтай зүйлс, сав ертөнц болох байгаль дэлхий, од гариг, тэнгэрийн эрхэс, агаар, орчинтойгоо харьцаж, тэдгээрийг танин мэдэж, ухаарч ойлгон, туршлага хуримтлуулсны үр

¹² Davitz, J.R

дүнд хэлний тогтвортой илэрхийллүүдийг бүтээж ирсэн нь өдөр тутмын харилцаа төдийгүй бичгийн эх сурвалжаас тодорхой байна.

Ц. Өнөрбаян “Нууц далд, эсвэл танин мэдээгүй шинэ юмс үзэгдлийг хүн төрөлхтөн ойлгож ухаарах гол арга зам нь ил буюу танин мэдсэн зүйлтэйгээ жишин харьцуулах, адилтган зүйрлэх арга юм.” (2011: 21) гэсэн байна.

Ж. Баянсан “Сэрэхүй мэдрэхүйд шууд эс тусах хийсвэр зүйл, хийсвэр ойлголтыг их төлөв адилтгалын аргаар нэршүүлэн тэмдэглэсэн байдаг нь их учиртай. Адилтгал, зүйрлэл нь нэг талаар үндэстний сэтгэлгээний хэв шинж, хэмжүүрийг тодорхойлох, нөгөө талаар тухайн соёл, хэлт үндэстний “ертөнцийг тухай хэлний дүр зураг онцлогийг судлан тайлбарлах нэг зүйлийн гэрч баримт болдог.” (2002: 33, 37) гэжээ.

Судлаачид танин мэдэхүйн зүйрлэлийг судалж, сурвалж хүрээ (бодит), зорилтот хүрээ (хийсвэр) хоёрын ижил төстэй талыг дараах байдлаар тодорхойлсон. Тухайлбал, “Уйтгар гуниг бол саванд байгаа шингэн” зүйрлэлийн сурвалж ба зорилтот хүрээний хоорондох буулгалтыг дараах байдлаар нотолсон байна.

Хүснэгт 1. “Уйтгар гуниг бол саванд байгаа шингэн” зүйрлэл

Сурвалж хүрээ	—————>	Зорилтот хүрээ
уйтгартай хүн	—————>	шингэн агуулсан сав
уйтгар гуниг	—————>	саванд буй шингэн
хүнд нөлөөлөх уйтгар гунигийн нөлөө	—————>	саван дахь шингэний даралт
уйтгар гунигийн шалтгаан	—————>	даралтын шалтгаан
уйтгар гунигаа барих	—————>	саванд буй юмыг тогтоох
уйтгартай буйн илрэл	—————>	шингэн савнаасаа халих

Танин мэдэхүйн хэл шинжлэлд САВ бүдүүвчийн хүрээнд үүссэн “уйтгар гуниг”-ийн тухай зүйрлэлийг дараах байдлаар бүтэцлэдэг.

- а) Уйтгар гуниг бол саванд байгаа шингэн.
- б) Уйтгар гунигт автах тусам шингэн савнаасаа хальдаг.
- в) Уйтгар гунигаа барьж дийлэхгүй бол сав тэсэрнэ.

Бид энэ судалгаанд гадаад, дотоодын судлаачдын дэвшүүлсэн онол үзэл баримтлалд тулгуурлан, монгол хэлний “уйтгар гуниг”-ийн тухай зүйрлэлийн сурвалж хүрээг дараах байдлаар тодорхойлж байна.

Sad is down/ уйтгартай бол доошоо

- Өөрийнх нь сэдсэн юманд тус болох гэж чармайж яваад эцэг нь зуурдаар нас барсанд Санж харамсавч барахгүй, *сэтгэлийн зовлонд унажээ*. (Л. Түдэв, Оройгүй сүм, х. 410)

- Гаднаа үргэлж инээд баясгалантай байдаг боловч **сэтгэлийн гүнд нь үргэлж гуниг үүрлэж** байдаг Гэрэлийн торомгор алаг нүд сэтгэлийг эзэлнэ. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 123)

Дүр бүдүүвчийг авч үзвэл “Уйтгар гуниг бол доошоо” зүйрлэл нь босоо бүдүүвчийн хүрээнд үүссэн байна. Босоо бүдүүвч нь уйтгар гунигийг хэмжих хэмжээс юм. Уйтгар гуниг нь босоо шугамын доод цэгт байрладаг тул “*Sad is down/ уйтгартай бол доошоо*” орон зайн зүйрлэл үүссэн байна. Босоо шугамын доод цэг рүү ойртох тусам уйтгар гуниг улам эрчтэй болдгийг дээрх жишээ харуулж байна. Орон зайн зүйрлэл үүсэх туршлагын үндэс нь биеийн байрлал, сэтгэл зүйн хариу үйлдэл хоёрын хоорондын холбоо юм. Ж. Баянсан “Хэлний аливаа адилтгал зүйрлэл үүсэх талбар нь эсрэг, тэсрэг хоёр туйлын хоорондох орон зай дахь үйл явдлын орчил юм.” (2016: 130) гэсэн байна.

Sad is dark/ уйтгартай бол харанхуй

- Түүний царайд **гунигийн хөх сүүдэр тодорхой**. (Л. Түдэв, Оройгүй сүм, х. 376)
- Энэ бүхнийг бодоход Эрэнчингийн **сэтгэлийг ямар ч гэрэл гэгээгүй бухимдал эзлэв**. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 284)

Sadness is a lack of heat/ уйтгартай байвал илч, дулаан дутагдана

- Хамрын уг нь шархирч гол өөд нь **хүйт оргилоо**. (С. Лочин. Сэтгэлийн өнгө)
- Тэр эр зоригоо гайхуулагчийг бахдан харах амьтан нэг ч үгүй бололтой, хааяа дуугарах буун дуугаар **нүдний гал буурах** нь “Миний ээлж хэзээ ирэх бол” гэсэн бодол баригчдын сэтгэл зэрэг төрдөггүйг илтгэнэ. (Ж. Пүрэв. Аянга)

Sadness is a lack of vitality/ уйтгартай бол эрч хүч дутагдана

- Гэрэлийг оршуулаад босох гэснээ Эрдэнийн нүд харанхуйлан, **бүх биеийн чадал нь алдраад** дайвахад нөхөд нь түшиж авлаа. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 344)
- Эрдэнийн царай ямар ч өнгөгүй болоод ганц үг дуугарсангүй. Үнэндээ **дуугарах ч чадал байсангүй** билээ. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х.100)

Дээрх танин мэдэхүйн зүйрлэлүүд САВ бүдүүвчийн хүрээнд үүссэн бөгөөд уйтгар гуниг бол сэтгэлийн өнгө аяс, төлөв байдлыг илэрхийлж байна. “Уйтгартай байвал илч, дулаан дутагдана/уйтгартай бол эрч хүч дутагдана” гэсэн хоёр төрлийн зүйрлэл нь хоорондоо холбоо хамааралтай. Эрч хүч буурсан үед биеийн дулаан буурч, бид уйтгартай байдалд ордог.

Sadness is a container/ уйтгар гуниг бол сав

- Бодолд нь төрсөн нутаг Сүхийн гол түүний алтан шар намар эргэлдэж, *сэтгэл нь уйтгараар дүүрнэ*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 234)
- Гэвч энэ бол нулимсгүй *битүү уйралт*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 46)
- Эрдэнийн энэ үгэнд Цэцэгийн царай хувхай цайвар болж *нүдэнд нь нулимс бүрхэв*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 145)

Sadness is a fluid in a container/ уйтгар гуниг бол саванд байгаа шингэн

- *Нулимс нь үе үе өөрийн эрхгүй асгарах* бөгөөд заримдаа унтаж байгаад хашхиран босож *эхэр татан уйлна*. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х.132)
- Хэрэв *нулимстай уйлахад гуниг гашуудал гадагш гардаг* бол *нулимсгүй уйлахад гуниг гаслал нь зүрхэнд орон тарж* шингэдэг юм. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 46)

Sadness is a physical force/ уйтгар гуниг бол физикийн хүч

- Гэвч гомдож хүйтэрсэн *сэтгэлийг хүчилж* болдоггүй бололтой. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х,142)

Уйтгар гуниг бол сав/ саванд байгаа шингэн/физик хүч зүйрлэлүүд САВ бүдүүвчийн хүрээнд үүссэн бөгөөд хүн өөрийн биеийг гадар, дотортой сав гэж ухаарч ойлгосон туршлагын үндэст суурилсан байна. Дээрх жишээнд саванд байгаа шингэний хэмжээ нь сэтгэл хөдлөлийн эрчийг тодорхойлж байна. Уйтгарт гунигт автсан үед хүн өөрийгөө хянаж чадахгүй байдалд орохыг хүч үйлчилсний үр дүнд шингэн савнаасаа хальдаг физик үзэгдэлтэй адилтган зүйрлэсэн байна.

Sadness is a natural phenomenon/ уйтгар гуниг бол байгалийн үзэгдэл

- Итгэлтийн үг дахин дахин сонстож, энэ үлэмж чадалтай хүн яах бол гэж санахад бие нь чичрэн, *сэтгэл нь харанхуй манангаар бүрхэж* байлаа. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 156)
- Бууны аманд онилуулсан Бадарчийн *сэтгэлд үхлийн хар цахилгаан цахиж* могой харсан хулгана шиг гөлрөв. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х 256)

Sadness is a natural force/уйтгар гуниг бол байгалийн хүч

- Гэлэн Чоймчогийн сэтгэл их л *гуниг гасланд живжээ*. (Л. Түдэв, Оройгүй сүм, х. 103)
- Хүн байгаль, дэлхийн юм, үзэгдэлтэй харьцаж, тэдгээрийг шинж чанар, хөдөлгөөн, төлөв байдлыг ойлгон ухаарч, мэдлэг туршлага хуримтлуулсан нь хэлэндээ хэрхэн туссаныг дээрх жишээ харуулж байна.

3. Көвэксес (1990) сэтгэл хөдлөлийг байгалийн хүчтэй холбон тайлбарлаж дараах дөрвөн үндсэн санааг дэвшүүлжээ.

1. Сэтгэл хөдлөл бол хүч бөгөөд түүнийг хянах чадвар хүнд дутмаг байдаг. Хүн идэвхгүй байх тусам сэтгэл хөдлөл бүдгэрэн алга болж түүнийг хянах боломжгүй болно.
2. Сэтгэл хөдлөл эрч хүч ихтэй гэдгийг зүйрлэлийн жишээ харуулж байна. Иймд сэтгэл хөдлөл бол "*Бага байвал байвал доошоо*" (*less is down*) зүйрлэлийг үүсгэж байна.
3. Сэтгэл хөдлөлийн хүч тодорхой нэг цэгээс хэтэрвэл хянах чадваргүй болоход хүрнэ. Ийм санааг илэрхийлсэн зүйрлэлүүд уйтгар гунигийн ангалд орвол бие болон оюун санааг хянах чадвар алдагддаг гэдгийг илэрхийлдэг.
4. Сэтгэл хөдлөл тун богино хугацаанд эрчилсэн салхи шиг гэнэт ирж биднийг хуу хаман авсаар аажмаар хүч нь сулардаг.

Sadness is an illness/уйтгар гуниг бол өвчин

- Зүс царай нь төдий л доройтоогүй мөртлөө *сэтгэлийн их зовууртай* нь илэрхий үзэгдэнэ. (Л. Түдэв, Оройгүй сүм, х. 5)
- Морио алдсаныг Бат сэрмэгц мэдэж *эцэг эхийнх нь гуниг сэтгэлд нь дамжин, ямар нэгэн хэцүү хар юм орогшиж байв.* (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 47)

Эдгээр зүйрлэлүүд сав бүдүүвчийн хүрээнд үүссэн байна. Хоёр дахь жишээнд *Уйтгар гуниг нь бол халдварт өвчин* гэсэн дэд айг үүсгэж байна. Уйтгар гуниг нь халдварт өвчний зарим шинжийг өөртөө агуулсан байдаг учир бусдад халдварладаг, хоруу чанартай гэсэн санааг энэ зүйрлэл илэрхийлж байна.

Sadness is a burden/ уйтгар гуниг бол ачаа

- "Таныг би удаан хүлээлээ" гэж Агваан санаа алдаад, "Тантай энэ аймшигт нууцыг хуваалцах гэж, *сэтгэлийн хүнд дарамтаа хөнгөлөх* гэж би таныг хүлээж байсан" гэв. (Л. Түдэв, Оройгүй сүм, х.498)
- Нэг ширхэг ч амьд юмгүй болсон мэт хар хорвоо Эрдэнийг *хавчин дарж байлаа.* (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х.80)

Дээрх зүйрлэлүүд нь хүнд бэрхийг өөрөө үүрч, биеэрээ туулах нь зүрх сэтгэлийг дааж ядам хүнд ачаа болгодог гэсэн утгатай. Эдгээр жишээнд уйтгар гунигийг сөргөөр үнэлж байгаа боловч аливаа юмын тэнцвэрийг тааруулах нь чухал гэсэн сургамжит далд санааг агуулсан байна.

Sadness is an opponent/ уйтгар гуниг бол өрсөлдөгч тал

- Долгор хатуу хувь заяандаа *дарагдан* цөхөрсөн хүн байлаа. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х.132)

- Долгор энэ *сэтгэлээ хүчлэн дарах* гэж оролдсон. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х.141)

Дээрх хэлний жишээ баримтаас үзэхэд *Уйтгар гуниг бол хүнд ачаа/ өрсөлдөгч тал* зүйрлэлүүд нь САВ бүдүүвчийн хүрээнд үүссэн байна. Дээрх зүйрлэлд өрсөлдөгч талдаа ялагдсан, өөрийгөө хамгаалах чадваргүй, хүч дорой хүний шинжийг уйтгар гунигт бүрэн автаж, эзлэгдсэн нэгэнтэй адилтган зүйрлэсэн байна.

Sadness is a social superior/ уйтгар гуниг бол нийгэмд эзлэх байр суурь

- “Бид нар ч *хөөрхий болтлоо ядуурч дээ*” гэж Сэндмаа *гуниглав*. Өглөө болгон олон үнээ саадаг айлд хоёр үнээ гэдэг хоосонтой адил юм даа. (Д.Оюунгэрэл, Ногоон нүдэн лам, х.291)
- Миний хүү айлын хүүхдүүдийг *ядуу гэж шоолбол битгий гутарч байгаарай*. (Д.Оюунгэрэл, Ногоон нүдэн лам, х. 484)

“*Уйтгар гуниг бол нийгэмд эзлэх байр суурь*” зүйрлэл нь босоо шулууны хүрээнд үүссэн байна. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн монголчуудын хувьд ядуу зүдүү, баян чинээлгийг тодорхойлох нэг жишиг хэмжүүр бол мал сүрэг юм. Дээрх хэлний жишээнээс *Хоосрол бол ядуурал* гэсэн зүйрлэл үүсэж байна. Иймээс мал гэх юмгүй, хэдхэн үнээ саах нь тарчиг ядуу, дутуу гуцуугийн илэрхийлэл болж байна.

Монгол хэлний жишээ баримтыг ажиглахад нэг өгүүлбэрт хоёр сурвалж хүрээ илрэх тохиолдол ажиглагдаж байна. Тухайлбал, **Баасангийн зүрх өвдөн дотор нь харанхуйллаа**. (Д.Оюунгэрэл, Ногоон нүдэн лам, х. 86). Энэ жишээнд “*Уйтгар гуниг бол өвчин, уйтгартай бол харанхуй*” гэсэн хоёр өөр сурвалж хүрээ илэрч байна. Эрдэнэ мориноос үсрэн буугаад Долгорын өмнөөс том том алхаад очиход Долгорын нүднээс *нулимс асгаран гэдэргээ өөрийн мэдэлгүй унав*. (Ч.Лодойдамба, Тунгалаг Тамир, х.141) Хоёр дахь жишээ нь “*Уйтгар гуниг бол сав, уйтгартай бол доошоо*” гэсэн хоёр сурвалж хүрээнээс бүтсэн байна. Эдгээр танин мэдэхүйн зүйрлэл нь дотоод ертөнцийн олон янзын үзэгдлийг илэрхийлж байна.

Хийсвэр ертөнц бол монголчуудын хувьд Сэтгэлийн ертөнц гэдэг нь дээрх хэлний баримтаас илэрхий байна. Мөн танин мэдэхүйн зүйрлэлүүд нь “сэтгэл” хэмээх оюунлаг, хийсвэр ертөнцийн шинж чанар, өнгө аяс, үйлдэл, ая занг дараах байдлаар илэрхийлдэг. Муу муухай, тааруу үйл явдал тохивол монгол хүн “сэтгэлээр унана” түүнээсээ гарч чадахгүй бол “сэтгэл давчидна, багтарна”, ямар нэг юмнаас уйдвал “сэтгэл холдоно”, ижилдэж дассан юм нь явчихвал “сэтгэл үгүйлнэ, эзгүйрнэ”, дассан зүйлээсээ холдож чадахгүй бол “сэтгэл хоргодно”, эзэнгүйрэн удвал “сэтгэл хөрнө”, эв зүйгээ олохгүй бол “сэтгэл хөндийрнө”, нэмж сэлбэхгүй бол “сэтгэл дундарна, хоосорно”, залж жолоодохгүй бол “сэтгэл тогтохгүй, сэтгэл алдуурна”, нэхлийг нь гүйцээхгүй бол “сэтгэл ханахгүй”, учрахгүй бол “сэтгэл хатуурна, атаархаж хорсоно”, хийх юмаа олохгүй бол “сэтгэл гэгэлзэнэ, дэнсэлнэ, тогтож ядна”, дотроо байгаа муу муухайг шавхаж гаргахгүй бол “сэтгэлд юм үлдэнэ”.

Эх сурвалжуудад "уйтгар гуниг"-ийг сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг хэллэг, тогтвортой илэрхийллүүд их илэрч байгаа нь монголчуудын хийсвэрлэх сэтгэлгээ өндөр түвшинд хөгжсөнийг илтгэж байна. Монгол хэлний үгийн сан ийнхүү баяжиж ирсэн нь эрт дээр үеэс аж төрж ирсэн нутаг, газарзүйн байршил, байгаль цаг уурын нөхцөл байдал, нүүдлийн амьдрал, байгалийн элдэв үзэгдлийн шинж төлөв зэрэг олон хүчин зүйлээс үүдэлтэй байна.

"Уйтгар гуниг" сэтгэл хөдлөл нь өөр сэтгэл хөдлөлтэй эсрэгцэн илрэх тал бий. *"Complex emotions are mixed substances"* / "Уйтгар гуниг бол саванд байгаа холилдсон шингэн" зүйрлэл нь сэтгэлийн энэ төлөв байдлыг илэрхийлдэг.

- *Mix joy and sorrow*-баяр гуниг **хосолсон** (OED);
- *I held my breath as I watched, feeling a mixture of happiness and sadness* (BNC)

Би тэр бүхнийг хараад амьсгаа авав. Баяр гуниг **хослон төрж байв**.

- Амьдралын хатуу ачаанд нуруугаа нухлуулсан Бат багын таних хүнтэй тааралдсанаа эцэг, эхтэйгээ уулзсан юм шиг баярлаж нүүрэнд нь **инээх уйлах хослов**. (Ч. Лодойдамба, Тунгалаг Тамир, х. 15)

Дээрх жишээнд хоёр сэтгэл хөдлөл зэрэгцэн оршиж байгааг өөр өнгийн бодистой адилтган зүйрлэж байгаа нь хүний сэтгэл олон өнгө төрхтэй, өнгө аястай гэдгийн илэрхийлэл юм. Мөн "сэтгэл" нь хүний зан чанар, харьцаа хандлага, үйл хэргийн шинжийг бүхэлд нь төлөөлж байна.

Дээрх танин мэдэхүйн зүйрлэлийн ихэнх нь хүний амьдралд тохиолдох хэрэг явдлын сөрөг байдлыг үнэлсэн үнэлэмж бүхий утгатай байна. Гэвч "уйтгар гуниг"-ийг илэрхийлсэн танин мэдэхүйн зүйрлэлийг зөвхөн сөрөг үнэлэмжтэй гэж үзэх нь өрөөсгөл болохыг дараах хэлний жишээ баримт харуулж байна.

Уйтгар гаслангаас

Уйлж салдаггүй (Д. Заяабаатар, х. 104)

Уйтгар дүүрсэн ордноос

Инээд бялхсан овоохой дээр (Д. Заяабаатар, х. 105)

Сэтгэлийн зовлонгоос

Биеийн зовлон (Д. Заяабаатар, х. 92)

Гаслан зовлон л бидэнд хамгаас аугаа, хамгаас ариун нандин бүхнийг хэлж өгдөг. (Г. Аюурзана, х. 362)

Жаргал зовлон тохиолдох хэмжээнээсээ бус, бид түүнийг аль хэр гүнзгий хүлээж авч байгаагаас л хамаардаг. (Г. Аюурзана, х. 276)

Every tear shed is a lesson learned, every pain endured a step towards growth.

Урсгасан нулимс бүхэн сургамж, тэвчиж гарсан өвдөлт бүхэн өсөн дэвших алхам болно.

Through the tears of sorrow, wisdom is distilled

Харамслын нулимс хүнд ухаан суулгадаг.

Монгол, англи хэлний дээрх зүйр цэцэн үгс “*Уйтгар гуниг бол сургамж*” гэсэн санааг агуулсан байна. Харуусаж гуних үед хүн илүү ухаарч, сэтгэлийн хаттай болдог учир уйтгар гуниг хүнийг ухааруулж, аливаа зүйлийг дээрдүүлдэг зүйл юм. Бид амьдралдаа олон зүйлийг таньж мэдэж, ухаарч ойлгон туршлага хуримтлуулж, алдаа онооноосоо суралцсанаар хүн шиг хүн болдог гэсэн үзэл соёл бүрд байдаг нийтлэг үзэгдэл болох нь дээрх хэлний баримтаас ажиглагдаж байна. Түүнчлэн, хүн амьдралдаа сайн болоод саар зүйлийг үзэж туулах нь нэг ёсны чухал сургамж болж, олон зүйлийг өөрчлөх үндэс болдог гэсэн гүн ухааны санаа шингэсэн байна.

Дээрх зүйрлэлүүд нь уйтгар гунигтай байсан ч түүнтэй тэмцэж, даван туулах боломжтой гэсэн санааг агуулсан байна. Уйтгар гуниг нь бидний ахиц, дэвшилд саад болж, ажлын бүтээмжийг бууруулдаг. Мөн хувь хүний хөгжил дэвшилд саад тотгор болж, аливаа зүйлийг сайн талаас нь биш, сөрөг талаас нь харахад хүргэдэг. Уйтгартай үед тархи бүрэн ажиллахгүй тул аливаа зүйлд төвлөрч чадахгүй. Иймд уйтгар гунигаас хол бай, гуньсан ч даван туул, түүнтэй тэмцэж ялан дийл. Сэтгэлийн амар амгалан бол аливаа сайн сайхан бүхний эх үндэс юм.

5. Судалгааны үр дүн (хэлэлцүүлэг)

Бодит ертөнц өөрийн гэсэн дүр зурагтай бол хэлний ертөнц ч мөн өөрийн гэсэн дүр зурагтай. Танин мэдэхүйн зүйрлэл бол хэлний ертөнцийн дүр зургийг илэрхийлэгч хэлний чухал хэрэглүүр юм. Танин мэдэхүйн хэл шинжлэлд гарт баригдаж, нүдэнд харагдахгүй тэрхүү нууцлаг ертөнцийн дүр зураг, мөн чанарыг судлаачид олон салбар ухаантай уялдуулан судалж, хэл соёл, сэтгэлгээний талаас тайлбарлахыг чухалчилж байна.


Сэтгэл хөдлөлийн үндсэн айн нэг болох “*уйтгар гуниг*” цогц ойлголт нь энэ судалгааны гол судлагдахуун юм. Монгол, англи хэлэнд сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд тархинд бүрэлдэн бий болсон цогц ойлголтын тогтолцоо чухал үүрэгтэй байна. Учир нь дохио буюу үгийн шилжсэн утга тархинд боловсруулагдаж, сэтгэхүй болон танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүнд хэлний зүйрлэл үүсдэгийг дээрх жишээ харуулж байна. Мөн хэлний зүйрлэл нь өөр өөр туршлага, соёлын үндэст суурилан үүсдэг нь хоёр хэлний сурвалж хүрэнээс ажиглагдаж байна.

Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн танин мэдэхүйн зүйрлэл хэл, соёл бүрд байдаг бөгөөд үндэстэн бүрийн ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг танин мэдэх арга ухаан өөр өөр гэдгийг илэрхийлдэг. Хүнийг тойрон буй материаллаг ертөнц ба амьдралын нөхцөл түүний ухамсар, танин мэдэхүйн сэтгэлгээг тодорхойлох бөгөөд энэ нь түүний хэлээр, ялангуяа утга зүй, хэл зүйн хэлбэрээр илэрдэг.

Судалгааны явцад монгол хэлэнд “*уйтгар гуниг*” сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн танин мэдэхүйн зүйрлэлийн утгын багтаамж, хүрээ их өргөн болох нь хэлний жишээ баримтаас ажиглагдаж байна.

Энэ судалгаанд 3. Көвөксесийн дэвшүүлсэн онол, үзэл баримтлал, өөр өөр хэл, соёлт ард түмний амьдралын туршлага, зүйрлэл үүсэх соёлын үндэст тулгуурлан "уйтгар гуниг"-ийн тухай зүйрлэлийн сурвалж хүрээг тодорхойлж, уг сэтгэл хөдлөлийн бүтцийг тодорхойлов. Монгол, англи хэлний "уйтгар гуниг"-ын тухай зүйрлэл нь сав + тоо хэмжээ (container+ quantity), юм + босоо шулуун (entity + verticality) гэсэн бүтэцтэй байна.

Хэлний жишээ баримтад ажиглалт хийхэд монгол, англи хэлний "уйтгар гуниг"-ийн тухай зүйрлэл нь дараах сурвалж хүрээтэй байна.



Үүнээс үзэхэд монгол, англи хэлний "уйтгар гуниг"-ийн тухай зүйрлэлийн сурвалж хүрээ нь ерөнхийдөө нийтлэг шинжтэй боловч, хэлний илэрхийлэл, сэтгэлгээний онцлогт ялгаатай шинж ажиглагдаж байна. Энэ судалгааны хүрээнд монгол, англи хэлэнд хэлний "Уйтгар гуниг бол физик хүч/галзуурал" зүйрлэл илэрц багатай байна. Бусад сурвалж хүрээний тухайд монгол хүн гадаад ертөнцтэй харьцах явцдаа сэтгэлийн мөн чанарыг таньж мэдэн, ухаарч ойлгосны үндсэн дээр биеийн хөдөлгөөн, соёлын туршлагын суурилан үүссэн *сэтгэл эмтрэх, сэтгэл хоосрох, сэтгэл өмрөх, сэтгэл гансрах* гэх мэт хэлний жишээ баримт эх сурвалжаас илэрч байна.

6. Дүгнэлт

Англи, монгол хэлний "уйтгар гуниг"-ийн тухай зүйрлэл нь дүр бүдүүвч, сав бүдүүвчийн хүрээнд үүссэн олон сурвалж хүрээтэй байна. Сав бүдүүвчийн хүрээнд үүссэн зүйрлэлүүд нь хүн өөрийн биеийг гадар, дотортой "Сав" гэж ухаарч ойлгон, таньж мэдсэн туршлагад суурилсан бөгөөд саванд байгаа шингэний хэмжээ нь сэтгэл хөдлөлийн эрчийг тодорхойлж байна. Босоо бүдүүвч нь уйтгар гунигийг хэмжих хэмжээс болж байна. Тухайлбал, "Sad is down/ уйтгартай бол доошоо" зүйрлэл үүсэх туршлагын үндэс нь биеийн байрлал, сэтгэл зүйн хариу үйлдэл хоёрын хоорондын холбоонд суурилсан байна.

Хоёр хэлэнд уйтгар гунигийг хийсвэрлэн илэрхийлэхэд нийтлэг шинж их илэрч байна. "Уйтгар гуниг бол сав/харанхуй" зүйрлэлүүд нь хоёр хэлэнд дууны

өнгө, нүд, нүүр царайгаар илрэхээс гадна монгол хүний сэтгэл зүрхний орон зайд илүү оршдог болох нь хэлний жишээ баримтаас ажиглагдаж байна. Сэтгэл хэмээх дотоод ертөнцөө монголчууд хэрхэн таньж мэдсэн нь байгаль дэлхий, мал сүрэгтэйгээ харьцаж ирсэн туршлага, нүүдлийн ахуй соёлтой холбоотой байна.

Энэ сэтгэл хөдлөл олон сурвалж хүрээтэй, нарийн бүтэц, тогтолцоотой байгаа нь монгол, англи үндэстний ертөнцийг үзэх үзэл, арга ухаан, сэтгэлгээний онцлогтой холбоотой. Монгол, англи хэлний уйтгар гунигийг илэрхийлсэн зүйрлэлүүд биеийн үйл хөдлөл, туршлагын үндэс, соёлд суурилан үүссэн бөгөөд өөр хэл, соёлт үндэстнүүд сэтгэл хөдлөлийг өөр өөрийн арга ухаанаар таньж мэддэг болохыг энэ судалгаа харуулж байна.

Ном зүй

- Аюурзана, Г.** (2007). *2x2=6 буюу Суут жаран сэтгэгч*. Улаанбаатар: Сорхон Цагаан ХХК. [Ayurzana, G. *2x2=6 buyu suut jaran setgegch* [2x2=6 or Great philosophers]. Ulaanbaatar: Sorkhon Tsagaan LLC. 2007.]
- Баянсан, Ж.** (2016). *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр. [Bayansan, J. *Soyol, hel, ündestnii setgelgee* [Culture, Language, Nation's Mentality]. Ulaanbaatar: Printing House. Mongolian National University. 2016.]
- Заяабаатар, Д.** (1999). *Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж*. Улаанбаатар. [Zayabaatar, D. *Mongol zuir tsetsen ugiin gурvan myangan deej* [The sampes of Mongolian proverbs with 3000 words] Ulaanbaatar: 1999]
- Түдэв, Л.** (2017). *Оройгүй сүм*. Улаанбаатар: Болор судар хэвлэлийн газар. [Tudev, L. *Oroigui süm* [The Temple Without a Pinnacle]. Ulaanbaatar: Bolor Sudar LLC. 2017.]
- Лодойдамба, Ч.** (2023). *Тунгалаг Тамир*. Улаанбаатар: Чадраабалын Лодойдамба сан. [Lodoidamba, Ch. *Tungalag tamir* [Translucent Tamir]. Ulaanbaatar: The Chadraabal Lodoidamda Foundation. 2003.]
- Оюунгэрэл, Д., Жеффри Л.Фалт.** (2008). *Ногоон нүдэн лам*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс. [Oyungerel, D & Jeffrey L. Falt. [*Green-eyed lama*]. Ulaanbaatar: Selenge Press. 2008.]
- Өнөрбаян, Ц.** (2011). Монгол хэлэнд туссан хийсвэр (дотоод) ертөнцийн дүр зураг. *Монгол судлалын чуулган, 11*: 30-31. [Önörbayan, Ts. The Image of the Inner World Reflected in the Mongolian Language. *Mongol sudlaliin chuulgan*, 2011, 11: 30-31.]
- Barcelona, A.** (1986). On the concept of depression in American English: A cognitive approach. *Revista Canaria de Estudios Ingleses, 12*, 7-33.
- Davitz, J. R.** (1969). *The language of emotion*. New York, NY: Academic Press.
- Lakoff, G., & Johnson, M.** (1980). *Metaphors we live by*. Chicago, IL: University of Chicago Press.
- Lakoff, G.** (1987). *Women, fire, and dangerous things: What categories reveal about the mind*. Chicago, IL: University of Chicago Press.

Johnson, M. (1987). *The body in the mind: The bodily basis of meaning, imagination, and reason*. Chicago,

IL: University of Chicago Press.

Kövecses, Z. (1990). *Emotion concepts*. New York, NY: Springer-Verlag.

Kövecses, Z. (2000). *Metaphor and emotion: Language, culture, and body in human feeling*. Cambridge, UK: Cambridge University Press.

Oyungerel, Ts., Jeffrey L. Falt. (2008). *Green-eyed lama*. Paris: Editions Grass



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.